



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 138

Номгон

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор
2017 онд олгосон зээлийн санхүүжилт, эргэн
төлөлтийн явцад хяналт, үнэлгээ хийж,
танилцуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци”-аас жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор 2017 онд олгосон 560,0 сая төгрөгийн зээлийн санхүүжилт, эргэн төлөлтийн явцад хяналт, үнэлгээ хийж, танилцуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Ганбаатар-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Н.Оюун-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Э.Цэнд-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

А.Тарва-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч

Д.Идэрханд-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч

2. Зээлийн санхүүжилт, эргэн төлөлтийн явцад хяналт, үнэлгээ хийсэн талаарх тайланг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит VIII хуралдаанд танилцуулахыг ажлын хэсэг /Д.Ганбаатар/-т даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

0117091